МЭДЭЭ · 2022 оны 4-р сарын 29

ЭРҮҮ ШҮҮЛТ ТУЛГАХААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ЗОРИЛГООР ШАЛГАЛТ ХИЙЛЭЭ



Хэнтий аймгийн прокурорын газраас эрүү шүүлт тулгах, хүний эрх зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх зорилгоор тус аймгийн Жаргалтхаан сум дахь Цагдаагийн тасагт шалгалт хийж, шаардлага хангахгүй өрөө, тасалгааг засварлаж, камержуулах талаар үүрэг чиглэл өгчээ.

Мөн үеэр "Шийдвэрлэлт" нэгдсэн арга хэмжээний явц байдлыг дүгнэж, мөрдөн шалгах ажиллагааны явцад гарч буй хүндрэл бэрхшээл, цаашид анхаарах асуудлаар үүрэг чиглэл өгсөн байна.